



**МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА**

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу, Засгийн газрын IV байр,
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2013-05-09 № 01/104

УУЯ-НЫ ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА Р.ЖИГЖИД
ТАНАА

Хөрөнгө оруулалтын төсөл, арга
хэмжээг хэрэгжүүлэх тухай

“Улсын төсвийн хөрөнгөөр 2012 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүн”-д гүйцэтгэлийн аудит хийлээ.

Тус яамны төсвийн багцад 2012 оны Төсийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулиар улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр батлагдсан хөрөнгө оруулалтаар “Алхана” ХХК-ийн Замын-Үүдэд гүйцэтгэж байгаа “Шингэн түлш шилжүүлэн ачих барилга байгууламжийн өргөтгөл”-ийн барилга угсралтын ажлын 930.1 сая төгрөгийн, “Синчи-Ойл” ХХК-ийн Улаанбаатар хотод гүйцэтгэж байгаа Газрын тосны газрын конторын барилгын өргөтгөлийн барилга угсралтын ажлын 840.0 сая төгрөгийн, нийт 1770.1 сая төгрөгийн 2 төсөл, арга хэмжээг гэрээний хугацаанд хэрэгжүүлээгүй буюу дутуу хэрэгжүүлсэн зөрчил, дутагдал илэрлээ.

Энэ нь Сангийн сайдын 2012 оны 12 дугаар сарын 27-ны 290 дугаар тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн журам”-ын 3.15, 5.3, 5.5-д заасныг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т “Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх ...”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2009 оны 47 дугаар тушаалаар батлагдсан “Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 3.1.1-д “... алдаа зөрчлийг арилгуулахаар Төрийн аудитын байгууллага холбогдох албан тушаалтанд албан шаардлага өгнө” гэсэн заалтыг үндэслэн ШААРДАХ НЬ:

1. Дорноговь аймгийн Замын-Үүдэд баригдаж байгаа Шингэн түлш шилжүүлэн ачих барилга байгууламжийн өргөтгөлийн ажлын дутуу 930.1 сая төгрөгийн ажлыг 2013 оны 11 дүгээр сарын 1-нд дуусган техникийн болон Улсын комисст хүлээлгэн өгөх арга хэмжээ авч тайлагнах,

2. ГТГ-ын конторын барилгын өргөтгөлийн 3 давхар барилгын ТЭЗҮ, зураг, төсвийн экспертизийн дүгнэлт хийлгэж ажлын гүйцэтгэлийг үндэслэн 2013 оны ХО-

071251

ын төсөл арга хэмжээнд тусгагдсан 840.0 сая төгрөгийн БУА-ыг 2013 оны 11 дүгээр сарын 1-ний дотор ашиглалтад оруулах ажлыг хэрэгжүүлэх,

3. Аудитаар илэрсэн зөрчлийг арилгаж, биелэлтийг гарган 2013 оны 11 дүгээр сарын 1-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг УУЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга Р.Жигжид, Эдийн засаг, санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Н.Энхбаяр нарт хариуцуулан албан шаардлага хүргүүлж байна.

Албан шаардлага бичсэн:

ҮАГ-ын аудитор



Ц.Эрдэнэчулуун